



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Налайх дүүрэгт шаврын орд ашиглан
тоосгоны үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн
нэгжүүдийн талаар авах зарим арга
хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.Е, 29.2 дахь хэсэг, “Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Налайх дүүргийн нутаг дэвсгэрт шаврын орд ашиглан, тоосгоны үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд нэгдсэн шалгалт хийж, хууль тогтоомжийн дагуу холбогдох хариуцлагын арга хэмжээ авах, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон шалгалтын дүнг 2014 оны 2 дугаар улиралд багтаан Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Г.Болормаа/-т даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

111020000605